

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШУА	Шинжлэх ухааны Академи
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	17
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МАТЕМАТИК, ТООН ТЕХНОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.УУГАНБААТАР ТАНАА

2021.02.25 № 07/479  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	<b><u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u></b>	00.00	00.00
34	<b><u>УРЬДЧИЛГАА</u></b>	<b>30,723,924.63</b>	<b>21,815,065.63</b>
34600	Урьдчилж гарсан зардал	30,723,924.63	21,815,065.63
35	<b><u>БАРАА МАТЕРИАЛ</u></b>	<b>1,767,099.00</b>	<b>3,502,680.00</b>
351	<b>Түүхий эд материал</b>	<b>371,800.00</b>	<b>577,500.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	371,800.00	577,500.00
354	<b>Хангамжийн материал</b>	<b>1,395,299.00</b>	<b>2,925,180.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,395,299.00	2,299,700.00
35420	Аж ахуйн материал	00.00	625,480.00
	<b><u>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</u></b>	<b>32,491,023.63</b>	<b>25,317,745.63</b>
2	<b><u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</u></b>		
39	<b><u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u></b>	<b>40,690,577.32</b>	<b>208,033,426.51</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>40,654,063.74</b>	<b>208,033,426.51</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,172,718.00	213,488,716.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,808,737.96)	(29,892,005.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,118,914.05	16,574,214.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,042,968.80)	(3,416,636.92)
39217	Ном	11,214,138.45	11,279,138.45
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>36,513.58</b>	<b>00.00</b>
39301	Программ хангамж	54,770.38	54,770.38
39302	Хуримтлагдсан элэгдэл	(18,256.80)	(54,770.38)
	<b><u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</u></b>	<b>40,690,577.32</b>	<b>208,033,426.51</b>
3	<b><u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</u></b>	<b>73,181,600.95</b>	<b>233,351,172.14</b>
5	<b><u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</u></b>	<b>73,181,600.95</b>	<b>233,351,172.14</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	73,181,600.95	233,351,172.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,560,540.88	44,560,540.88
51101	Өмч: - төрийн	44,560,540.88	44,560,540.88
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	28,621,060.07	188,790,631.26
51210	Өмнөх үеийн үр дүн	28,621,060.07	28,621,060.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	160,169,571.17
6	<b><u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</u></b>	<b>73,181,600.95</b>	<b>233,351,172.14</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>216,790,210.88</b>	<b>906,380,520.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>48,804,710.88</b>	<b>42,346,420.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	48,804,710.88	42,346,420.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,804,710.88	42,346,420.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	20,398,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,804,710.88	21,948,020.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>167,985,500.00</b>	<b>864,034,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	167,985,500.00	772,694,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	167,985,500.00	772,694,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	91,339,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	87,119,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,220,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>174,332,534.56</b>	<b>746,210,948.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>174,332,534.56</b>	<b>746,210,948.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	174,284,845.79	647,589,638.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	129,183,411.59	465,243,029.70
210101	Үндсэн цалин	115,824,300.00	370,583,309.80
210102	Нэмэгдэл	10,432,400.00	71,104,280.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,926,711.59	23,555,439.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,903,328.68	56,307,707.15
210201	Тэтгэврийн даатгал	13,111,000.00	38,688,974.55
210202	Тэтгэмжийн даатгал	670,228.68	4,079,008.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	565,700.00	3,834,623.34
210204	Ажилгүйдлийн даатгал	141,700.00	740,688.14
210205	Эрүүл мэндийн даатгал	1,414,700.00	8,964,412.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,209,491.00	11,447,201.31
210401	Бичиг хэрэг	4,141,974.19	8,006,396.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	67,516.81	348,405.31
210404	Ном, хэвлэл	00.00	935,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,157,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	12,800,000.00
210604	Урсгал засвар	00.00	12,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	777,200.00
210702	Дотоод албан томилолт	00.00	777,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,118,650.96	70,401,052.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,118,650.96	68,901,052.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,869,963.56	30,613,448.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,869,963.56	29,493,448.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	47,688.77	98,621,309.84
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	1,790,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,510,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	280,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	47,688.77	96,831,309.84
213303	Урсгал санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	47,688.77	96,829,347.84
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,962.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>42,457,676.32</b>	<b>160,169,571.17</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>167,985,500.00</b>	<b>864,034,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>167,985,500.00</b>	<b>864,034,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	167,985,500.00	772,694,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	167,985,500.00	772,694,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	91,339,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	87,119,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,220,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>167,985,500.00</b>	<b>709,544,222.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>167,985,500.00</b>	<b>709,544,222.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>167,937,811.23</b>	<b>610,922,912.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	129,183,411.59	465,243,029.70
210101	Үндсэн цалин	115,824,300.00	370,583,309.80
210102	Нэмэгдэл	10,432,400.00	71,104,280.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,926,711.59	23,555,439.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,903,328.68	56,307,707.15
210201	Тэтгэврийн даатгал	13,111,000.00	38,688,974.55
210202	Тэтгэмжийн даатгал	670,228.68	4,079,008.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	565,700.00	3,834,623.34
210204	Ажилгүйдлийн даатгал	141,700.00	740,688.14
210205	Эрүүл мэндийн даатгал	1,414,700.00	8,964,412.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,580,000.00	5,515,905.31
210401	Бичиг хэрэг	2,490,181.19	1,512,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	67,516.81	348,405.31
210404	Ном, хэвлэл	00.00	935,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,022,302.00	2,720,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	12,983,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	183,700.00
210604	Урсгал засвар	00.00	12,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	777,200.00
210702	Дотоод албан томилолт	00.00	777,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,271,070.96	68,705,370.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,271,070.96	67,205,370.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	1,390,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,390,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,688.77</b>	<b>98,621,309.84</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	1,790,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,790,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	47,688.77	96,831,309.84
213303	Урсгал санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	47,688.77	96,829,347.84
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,962.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>154,489,878.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
<b>5</b>	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	154,489,878.00
<b>22</b>	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	154,489,878.00
<b>2200</b>	Дотоод эх үүсвэрээр	00.00	154,489,878.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	154,489,878.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>(154,489,878.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	44,560,540.88	00.00	(13,836,616.26)	<b>00.00</b>	30,723,924.63
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	42,457,676.32	00.00	42,457,676.32
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	44,560,540.88	00.00	28,621,060.07	<b>00.00</b>	73,181,600.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	44,560,540.88	00.00	28,621,060.07	<b>00.00</b>	73,181,600.95
D08	Тайлант үеийн үр дүн			160,169,571.17		160,169,571.17
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>44,560,540.88</b>	<b>00.00</b>	<b>188,790,631.26</b>	<b>00.00</b>	<b>233,351,172.17</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		0.00	0.00	
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>772,694,400.00</b>	<b>675,865,052.16</b>	<b>96,823,347.84</b>	<b>87.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>772,694,400.00</b>	<b>675,865,052.16</b>	<b>96,823,347.84</b>	<b>87.5</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>770,904,200.00</b>	<b>674,075,052.16</b>	<b>96,829,147.84</b>	<b>87.4</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>539,626,800.00</b>	<b>465,243,029.70</b>	<b>74,383,770.30</b>	<b>86.2</b>
210101	Үндсэн цалин	416,499,600.00	370,583,309.80	45,916,290.20	89.0
210102	Нэмэгдэл	84,688,800.00	71,104,280.90	13,584,519.10	84.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,438,400.00	23,555,439.00	14,882,961.00	61.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,440,600.00</b>	<b>56,307,707.15</b>	<b>22,132,892.85</b>	<b>71.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,199,000.00	38,688,974.55	16,510,025.45	70.1
210202	Тэтгэмжийн даатгал	5,810,400.00	4,079,008.14	1,731,391.86	70.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,648,300.00	3,834,623.34	813,676.66	82.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,162,100.00	740,688.14	421,411.86	63.7
210205	Эрүүл мэндийн даатгал	11,620,800.00	8,964,412.98	2,656,387.02	77.1
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,632,800.00</b>	<b>5,580,905.31</b>	<b>51,894.69</b>	<b>99.1</b>
210401	Бичиг хэрэг	1,512,500.00	1,512,500.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,300.00	348,405.31	51,894.69	87.0
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,720,000.00	2,720,000.00	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>138,294,000.00</b>	<b>138,276,210.00</b>	<b>17,790.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	125,494,000.00	125,476,210.00	17,790.00	100.0
210604	Урсгал засвар	12,800,000.00	12,800,000.00	-	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>777,200.00</b>	<b>222,800.00</b>	<b>77.7</b>
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	777,200.00	222,800.00	77.7
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,500,000.00</b>	<b>6,500,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,410,000.00</b>	<b>1,390,000.00</b>	<b>20,000.00</b>	<b>98.6</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,410,000.00	1,390,000.00	20,000.00	98.6
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,790,200.00</b>	<b>1,790,000.00</b>	<b>200.00</b>	<b>100.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,790,200.00	1,790,000.00	200.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>772,694,400.00</b>	<b>675,865,052.16</b>	<b>96,829,347.84</b>	<b>87.5</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>772,694,400.00</b>	<b>675,865,052.16</b>	<b>96,829,347.84</b>	<b>87.5</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	772,694,400.00	675,865,052.16	96,829,347.84	87.5
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>-</b>	<b>-</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>-</b>	<b>-</b>

<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	45	42	-	93,3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	44	41	-	93.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>91,339,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>91,339,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		91,337,738.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		91,337,738.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		91,337,738.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>1,962.00</b>
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		1,962.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		91339700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		91,339,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		87,119,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,220,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ууганбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлт, шилэн дансны мэдээлэл, худалдан авах ажиллагаа, архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 25-наас 2021 оны 2 дугаар сарын 05-ны хооронд эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитор Д.Жаргалсайхан, Д.Насанжаргал, Ч.Ням-Очир нар хариуцаж хэрэгжүүлэв.

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 1/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Математик, тоон технологийн хүрээлэнгийн тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилго, зорилт, түүний хэрэгжилтийн талаарх товч мэдээлэл:

Математик, тоон технологийн хүрээлэн нь эрхэм зорилго “Математик, тоон технологийн судалгааг хөгжүүлж, “ШИНЭ МЭДЛЭГ”-ийг бүтээнэ” гэж тодорхойлсон байна. Үүнд:

- Шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх
- Математикийн салбарт хэрэгжиж буй суурь судалгааны төслүүдийг хэрэгжүүлэх
- Тусгай захиалгат бүтээгдэхүүнийг нийлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Коронавируст халдвар Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2020.02.28-ны 78 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020.03.27-ны 114 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2020.04.15-ны 139 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2020.05.06-ны 168 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020.11.18-ны 183 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020.11.23-ны 188 дугаар тогтоол

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Математик, тоон технологийн хүрээлэнгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Математик, тоон технологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 746,210.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 14,924.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160,169.6 мянган төгрөгөөр буюу 318.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	30,723.9	21,815.1	(8,908.8)
Бараа материал	1,767.1	3,502.7	1,735.6
Үндсэн хөрөнгө	40,654.1	208,033.4	167,379.3
Биет бус хөрөнгө	36.5	0.0	(36.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>73,181.6</b>	<b>233,351.2</b>	<b>160,169.6</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	73,181.6	233,351.2	160,169.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>73,181.6</b>	<b>233,351.2</b>	<b>160,169.6</b>

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 21,815.1 мянган төгрөг болж 8,908.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад тус байгууллагаар дамжин санхүүжигдсэн БШУЯ-ны захиалгатай эрдэм шинжилгээний ажлын тайланг дуусган хүлээлгэн өгснөөс шалтгаалжээ. Тайлант онд ажлыг дуусган хүлээлгэн өгөөгүй 3 эрдэм шинжилгээний ажил үлдсэн байна.



Бараа материалын дансны үлдэгдэл 3,502.7 мянган төгрөг болж 1,735.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалт, бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Энэ нь гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, технологийн ажлын онцлогоос шалтгаалан бараа материалыг бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 208,033.4 мянган төгрөг болж 167,379.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 167,379.9 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн байна.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, 71 нэр төрлийн 74,904.5 мянган төгрөгийн, элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх өртөг нь тэг төгрөг байсан үндсэн хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл тэг төгрөг болж 36.5 мянган төгрөгөөр буурсан нь биет бус хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 233,351.2 мянган төгрөг болж 160,169.6 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 689,590.3 мянган төгрөгөөр буюу 418.1 хувиар өссөн нь урсгал санхүүжилт нэмэгдсэн шалтаантай.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, төсөвт байгууллагын өөрийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлогууд байна. Энэ нь тус хүрээлэн нь шинээр байгуулагдсан болон төсвийн санхүүжилт нэмэгдсэнээс шалтгаалан өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 746,210.9 мянган төгрөгөөр буюу 428.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материал, эд хогшил худалдан авах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь тус хүрээлэнгийн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан гарсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 819,816.2 мянган төгрөгөөр нийт зарлагыг 819,816.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 47,121.8 мянган төгрөгөөр бууруулж 772,694.4 мянган төгрөгөөр баталсан байна. 2020 оны төсвийн төсөл нь 2019 оны батлагдсан төсвөөс 651,830.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл, бараа үйлчилгээний бусад зардлуудыг нэмэгдүүлсэн байна.

## **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 772,694.4 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 772,694.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 675,865.0 мянган төгрөгийг зарцуулж 96,829.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 675,865.0 мянган төгрөг буюу 87.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулалын зардлыг 74,383.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэлийн зардлыг 22,132.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 51.9 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 17.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 222.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 20.0 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь шинжлэх ухаан, технологи хөтөлбөрийн эрдэм шинжилгээ судалгаа арга хэмжээг 96,829.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Энэ нь тайлант онд орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор зардлын хэмнэлт гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны захирагчид хувиарилсан буюу төслийн санхүүжилт 87,119.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,220.0 мянган төгрөг нийт 91,339.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 91,337.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

## **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 174 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 20 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Шилэн дансны мэдээлэлд 5.0 сая төгрөгнөөс дээш 952,381.3 мянган төгрөгийн орлогын болон зарлагын гүйлгээнүүдийг шилэн дансанд байршуулаагүй байна. Мөн шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн ямар нэгэн тухаал шийдвэрийг оруулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 210,410.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 203,819.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,279.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2,312.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 95,362.9 мянган төгрөгийн балансын үнэтэй, 61,771.9 мянган төгрөгийн элэгдэлтэй үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байсныг залруулав.
2. Тайлант хугацаанд 68,632.5 мянган төгрөгийн балансын үнэтэй болон байгуулсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр ашиглалтын хугацааг сунгаж, 21,948.0 мянган төгрөгөөр үнийг бууруулан шинэчлэн тогтоосон бөгөөд зөрүү 46,684.5 мянган төгрөгийг бүртгэл тайланд тусгаагүй байсныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 4,279.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд зохион байгуулсан ШУА-2020-07 тендерт гүйцэтгэлийн баталгаа аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.”, 43.3 “Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээлцэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.”, 43.4 “Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана.”, 43.4.2 “100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;” заалтыг мөрдөж ажиллах, УСНББОУС1-ийн 27 зүйл: “үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг.” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

2. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансанд хуулиар оруулах 952,381.3 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байгаа зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” заалтууд, УСНББОУС1-ийн 27 дугаар зүйл: “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан

хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг.” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 2,312.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

1. Холбогдох байгууллагын шийдвэрээр шилжиж ирсэн үндсэн хөрөнгө болон бараа материалын бүртгэл хөтлөлт, дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Худалдан авалттай холбоотой асуудал:

###### 1.1. Илрүүлэлт:

2020 оны худалдан авалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Тайлант онд багаж техник хэрэгсэл худалдан авах 125,494.0 мянган төгрөгийн тендерийн төсөвт өртгийг хувааж тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлого буюу Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлсэн төслийн санхүүжилтийн хөрөнгөөр 29,132.4 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг тендер шалгаруулалт зохион байгуулаагүй худалдан авсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.” заалтууд, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.

###### 1.2. Эрсдэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмыг хэрэгжүүлж ажилаагүй байх, энэ нь төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, авлага, өр төлбөр үүсэх,

###### 1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.” заалтууд, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах,

###### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Манай хүрээлэнгийн үндсэн зорилт, чиглэлийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд шаардлагатай 2 ширхэг супер компьютер, өндөр хүчин чадалтай тог баригч худалдан авахаар төлөвлөж, хүрээлэнгийн 2020 оны төсөвт батлуулсан билээ. Улмаар Шинжлэх ухааны Академиас нээлттэй тендер шалгаруулалтаар зарлаж, шаардлага хангасан гүйцэтгэгчээр “ITZONE” ХХК-ийг шалгаруулж, 85,582.31 мянган төгрөгөөр гэрээ байгуулан 2 ширхэг супер компьютер, өндөр хүчин чадалтай тог баригчийг хүлээн авсан. Дээрх тендер шалгаруулалтаас хэмнэгдсэн төсвөөр хүрээлэнгийн машин сургалтын лабораторид шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсний дагуу тендер зарлаж, гүйцэтгэгчээр Монтех дистрибьюшн ХХК-ийг шалгаруулж, гэрээний дагуу барааг хүлээн авсан болно. Харин суурь судалгааны төслийн төсвийг уг төслийн удирдагч ШУТС-тай байгуулсан гэрээний дагуу зарцуулдаг тул нэгдсэн худалдан авалтын төлөвлөгөө гардаггүй болно. Цаашид Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах болно.

##### 2. Дотоод хяналттай холбоотой асуудал

###### 2.1. Илрүүлэлт:

Харилцах дансны гүйлгээг баримттай тулган баталгаажуулж шалгахад баримтын бүрдэлүүд хийгдсэн ч маш эмх цэгцгүй үдэгдсэн байна. Тухайлбал цалингийн холбогдолтой бүх баримтууд, захирлын тушаалууд хамт үдэгдсэн. Цахим архивыг бүрдүүлээгүй байна.

## 2.2. Эрсдэл:

Архивын хууль, журмыг хэрэгжүүлж ажиллагаагүй байх, энэ нь байгууллагын архивын сан хөмрөгийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглах болон албан хэрэг хөтлөлтийг дутуу, буруу хөтөлсөн байх үр дагавартай.

## 2.3. Өгсөн зөвлөмж:

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 "Байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална." заалтыг мөрдөж ажиллах,

## 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Харилцахын баримтын эмх цэгцийг сайжруулж, холбогдох материалуудыг журмын дагуу салгаж, архивлана. Цаашид архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг мөрдөж ажиллана.

## 3. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

### 3.1 Илрүүлэлт:

Тайлант онд Samsung EVO internalSSD пам, USB 2tb hdd, Зөөврийн хард 2тр 3 ширхэг нийт 2,312.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалын шаардах хуудсанд байгууллагын удирдлага нь зөвшөөрч гарын үсэг зураагүй байна.

### 3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй байх, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд тусгасан байх эрсдэлтэй,

### 3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" заалтуудыг мөрдөж ажиллах,

### 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллана. Мөн бараа материалын шаардах хуудсанд байгууллагын удирдлагын гарын үсгийг зуруулж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.08</b>	Аудитын нэр: <b>Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/142/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Математик, тоон технологийн хүрээлэн ТШЗ</b>	Мянган төгрөг: <b>Мянган төгрөг</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд зохион байгуулсан ШУА-2020-07 тендерт гүйцэтгэлийн баталгаа аваагүй байна.	4,279.1	Албан шаардлага	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Ууганбаатар, М.Буяннэмэх
2	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, зарим мэдээлэл дутуу байна.	-	Албан шаардлага	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Ууганбаатар, М.Буяннэмэх
3	2020 оны худалдан авалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна. Тайлант онд багаж техник хэрэгсэл худалдан авах 125,494.0 мянган төгрөгийн тендерийн төсөвт өртгийг хувааж тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлого буюу Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлсэн төслийн санхүүжилтийн хөрөнгөөр 29,132.4 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг тендер шалгаруулалт зохион байгуулаагүй худалдан авсан байна.	-	Зөвлөмж	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Ууганбаатар, М.Буяннэмэх
4	Харилцах дансны гүйлгээг баримттай тулган баталгаажуулж шалгахад баримтын бүрдэлүүд хийгдсэн ч маш эмх цэгцгүй үдэгдсэн байна. Тухайлбал цалингийн холбогдолтой бүх баримтууд, захирлын тушаалууд хамт үдэгдсэн. Цахим архивыг бүрдүүлээгүй байна. Цахим архивыг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.	-	Зөвлөмж	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Ууганбаатар, М.Буяннэмэх
5	Тайлант онд Samsung EVO internalSSD ram, USB 2tb hdd, Зөөврийн хард 2тр 3 ширхэг нийт 2,312.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалын шаардах хуудсанд байгууллагын удирдлага нь зөвшөөрч гарын үсэг зураагүй байна.	2,312.4	Зөвлөмж	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Ууганбаатар, М.Буяннэмэх
<b>ДҮН</b>		<b>6,591.5</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 24/АО160058

Улаанбаатар хот

САГ-2021/142/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 174 мэдээллээс хугацаа хоцроосон 3 мэдээлэл, мөн 20 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"; 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Математик, тоон технологийн хүрээлэнгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ууганбаатар, ахлах нягтлан бодогч М.Буяннэмэх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар5.Docx

001081033





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 23/АДИ 6 005 В

Улаанбаатар хот

САГ-2021/142/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Математик, тоон технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд зохион байгуулсан ШУА-2020-07 тендерт 4,279.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.”, 43.4-т “Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана.”, 43.4.2-т “100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд зохион байгуулсан ШУА-2020-07 тендерт гүйцэтгэлийн баталгаа аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Математик, тоон технологийн хүрээлэнгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ууганбаатар, ахлах нягтлан бодогч М.Буяннэмэх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Д.ЭХБЯАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2021\022Sauditin 2-R Газар 4.Docx

001081029





